

ТАНИЛЦУУЛГА

Төрийн албаны тухай /шинэчилсэн найруулга/ хуулийн 68.1-д Төрийн албаны зөвлөл нь хамтын удирдлагын зарчмаар ажиллах бөгөөд орон тооны таван гишүүний бүрэлдэхүүнтэй байхаар заасан тул “Төрийн албан хаагчийн төлөөллийг сонгон шалгаруулах журам”-ыг боловсруулах шаардлагаар Монгол Улсын бусад хамтын удирдлагын байгууллагуудын туршлага, холбогдох хууль тогтоомж, бусад орны туршлагыг судалсан болно.

Мөн эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем legalinfo.mn цахим сайтаас хамтын удирдлагын байгууллагуудын дүрэм, журмыг шүүн үзлээ. Тухайлбал Шүүхийн ерөнхий зөвлөл, Санхүүгийн зохицуулах хорооны хяналтын зөвлөл, Монгол Улсын Үндсэн хуулийн цэц, Гаалийн тарифын зөвлөл, Сургууль цэцэрлэгийн зөвлөл, Татварын маргаан таслах зөвлөл, Авлигатай тэмцэх газрын дэргэдэх орон тооны бус олон нийтийн зөвлөл гэх зэрэг 20 гаруй хууль, дүрэм журмыг нэгтгэж холбогдох хууль тогтоомж, байгууллагын нэр, бүрэлдэхүүний тоо, тавигдах шаардлага, гишүүдийн томилгоо хаанаас ямар замаар хийгддэг зэрэг үзүүлэлтийг нарийвчлан судаллаа.

Түүнээс гадна Япон, Канад, Сингапур, Тайланд улсын төрийн байгууллагын бүтцээс Монгол Улсын Төрийн албаны зөвлөлтэй ижил чиг үүрэг бүхий байгууллагын гишүүнийг томилох зарчим, тэдгээр тавигдах шаардлага, зарим улсын ижил төстэй хамтын удирдлагын байгууллагын гишүүний томилгооны талаар судлав.

Журмын төслийг боловсруулж эхлэхээс өмнө Төрийн албаны зөвлөлийн гишүүн буюу төрийн албан хаагчийг сонгон шалгаруулах зохицуулалт нь Төрийн албаны тухай /шинэчилсэн найруулга/ хуульд орсон шинэ зохицуулалт тул Улсын Их Хурлын зарим гишүүн, Төрийн албаны зөвлөлийн дарга, гишүүн, Ажлын албаны даргаар ажиллаж байсан хүмүүс, Төрийн албаны судлаачид зэрэг 10 орчим иргэнтэй уулзаж “төрийн албаны хаагчийн төлөөлөл” гэснийг хэрхэн ойлгож байгаа, журмын төсөлд тусгагдах шаардлагатай асуудлууд, анхаарах асуудлын талаар санал солилцсоны үндсэн дээр боловсруулсан болно.

Эдгээр мэдээлэл, судалгаанд үндэслэн журмын төслийг боловсруулахдаа төрийн албан хаагчийн төлөөллөөр өндөр ёс суртахуунтай, зохих мэдлэг, туршлага, ур чадвартай хүнийг сонгон шалгаруулахыг зорилго болгов.

Төрийн албаны тухай /шинэчилсэн найруулга/ хуулийн үндсэн үзэл санаа болох мерит зарчимтай уялдуулах үүднээс хуульд тусгагдсан Зөвлөлийн гишүүнд тавигдах шаардлагыг дэлгэрүүлэн тусгаж эрхэлсэн түшмэлийн болон түүнээс дээших албан тушаалд 5-аас доошгүй жил ажилласан байх шаардлагыг тусгав. Ингэхдээ Зөвлөлийн гишүүн нь Төрийн өндөр албан тушаал бөгөөд түүний доод шатны албан тушаал нь тэргүүн түшмэл буюу Яамны төрийн нарийн бичгийн дарга, Агентлагийн дарга боловч сонгон шалгаруулалтад оролцох

боломжтой иргэдийг хэт хязгаарлаж болзошгүй гэж үзэж эрхэлсэн түшмэлд 5 жил ажилласан байхаар тусгасан болно.

Мөн Төрийн албаны тухай хуульд тавигдсан мэргэшлийн шаардлага бүр нь зөвлөл чиг үүргээ үр дүнтэй гүйцэтгэхэд хувь нэмэр оруулах учир сонгон аль болох олон янзын мэргэшилтэй гишүүд байхыг дэмжих зарчмыг тусгав. Түүнчлэн Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль нийцүүлэн аль нэг хүйсийн төлөөлөл хэт давамгайлахгүй зарчмыг тусгасан болно.

Сонгон шалгаруулах процессын хувьд сонгон шалгаруулалтыг Төрийн албаны зөвлөлөөс ажлын 15 хоногийн хугацаанд зарлаж шаардлага хангасан иргэд бүртгүүлэхээр тусгалаа.

Сонгон шалгаруулалтыг хөндлөнгийн нөлөөгүй шударга явуулах зорилгоор сонгон шалгаруулалтыг зохион байгуулах комисс 5 хүний бүрэлдэхүүнтэй, олон янзын төлөөллөөс бүрдэхээр тусгав. Тухайлбал нэр дэвшүүлсэн гишүүд Улсын Их Хурлаас томилогдох, Төрийн байгуулалтын байнгын хороо нэр дэвшигчдийн талаар дүгнэлт гаргах учир сонгон шалгаруулалтын явцад хяналт тавих, сонгон шалгаруулалтад оролцох үүднээс Төрийн байгуулалтын хорооны төлөөлөл комисст орсон болно. Төрийн албаны зөвлөлийн Ажлын алба сонгон шалгаруулалтыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлж ажиллах шаардлагатай учир Төрийн албаны зөвлөлийн төлөөллийг комисст оруулахаар заав. Төрийн албаны зөвлөлийн гишүүнд УИХ-н Тамгын газар, Ерөнхийлөгчийн Тамгын газар, ЗГХЭГ-с тус бүр нэг хүнийг нэр дэвшүүлэх учир төрийн албан хаагчийн төлөөллийг сонгон шалгаруулахад шүүх засаглалын хяналтыг оруулах зорилгоор Шүүхийн ерөнхий зөвлөлийн төлөөлөл орохоор мөн заав. Сонгон шалгаруулалт шударга явагдахад хяналт тавих үүднээс Үндэсний аудитын газар, түүнчлэн ТАТХ-н 56-р зүйлд заасан Олон нийтийн хяналтын зөвлөлийн төлөөллийг оролцуулахаар заалаа.

ТАТХ-д Зөвлөлийн гишүүд нэг нутгийн, нэг анги хамт төгссөн байх үеийн зохицуулалт болон журам зөрчигчид хүлээлгэх хариуцлага зэрэг бусад асуудлыг мөн журмын төсөлд тусгав.

-оОо-

**ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ТӨЛӨӨЛЛИЙГ
СОНГОН ШАЛГАРУУЛАХ
ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Төрийн албаны тухай /шинэчилсэн найруулга/ хуулийн 68.2 дахь хэсэгт заасан Төрийн албан хаагчийн төлөөллийг сонгон шалгаруулах, Төрийн албаны зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлэх болон холбогдох бусад ажиллагааг энэ журмаар зохицуулна.

1.2.Төрийн албан хаагчийн төлөөллийг сонгон шалгаруулах ажлын зорилго нь төрийн албан хаагчийн өндөр ёс зүйтэй, Зөвлөлийн чиг үүргийг гүйцэтгэхэд арга зүйн удирдлагаар хангаж ажиллах мэдлэг, туршлага, ур чадвартай төрийн албан хаагчийг шилж сонгоход оршино.

1.3.Төрийн албан хаагчийн төлөөллийг сонгон шалгаруулахад шударга байх, аливаа хөндлөнгийн нөлөөллөөс ангид байх, ил тод байх, нэг хүйсийн хүн хэт давамгайлахгүй байх, мэргэшлийн хувьд аль болох олон янзын төлөөллийг хангах, улс төрийн аль нэг хүчинд ажиллаж байсан иргэн гишүүдийн талаас илүүгүй байх зарчмыг баримтална.

1.4.Энэхүү журмын дагуу Төрийн албаны зөвлөлийн гишүүнд нэр дэвшигч нь дараахь шаардлагыг хангасан байна. Үүнд:

1/төрийн жинхэнэ албан тушаалд 15-аас доошгүй жил ажилласан байх, үүнээс эрхэлсэн түшмэлийн болон түүнээс дээших албан тушаалд 5-аас доошгүй жил ажилласан байх,

2/төрийн удирдлага, эдийн засаг, эрх зүй, боловсролын чиглэлээр мэргэшсэн байх,

3/дээд боловсролтой байх,

4/дөчин таван нас хүрсэн байх,

5/сахилгын шийтгэлээр төрийн албанаас халагдах болон ёс зүйн зөрчил гаргаж байгаагүй байх,

6/ял шийтгүүлж байгаагүй байх,

1.5.Энэ журмын 1.4.3-д заасан тухайн чиглэлээр мэргэшсэн гэдэгт тухайн чиглэлийн мэргэжилтэй эсхүл тухайн чиглэлээр бакалавраас дээш зэрэг

хамгаалсан эсхүл тухайн салбарын бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, хяналт тавих чиг үүрэг бүхий албан тушаалд 6-аас доошгүй жил ажилласан байхыг ойлгоно.

1.6.Төрийн албан хаагчийн төлөөлөл гэж төрийн албанд ажиллаж буй, зөвлөлийн гишүүнд тавигдах шаардлагыг хангаж комиссын сонгон шалгаруулалтаар шалгарсан иргэнийг хэлнэ.

Хоёр. Сонгон шалгаруулалтыг мэдээлэх

2.1.Төрийн албаны зөвлөлийн гишүүний сул орсон тоо гарсан тохиолдолд сонгон шалгаруулалт явуулахаас ажлын 15-аас доошгүй хоногийн өмнө Төрийн албаны зөвлөл сонгон шалгаруулалтын талаар хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлнэ.

2.2.Мэдээлэлд энэ журмын дагуу нэр дэвшигчид тавигдах шаардлага, бүрдүүлэх материал, бүртгэх болон сонгон шалгаруулалт явуулах байр, хугацаа зэргийг заана. Мэдээлэлд өөрчлөлт оруулах зайлшгүй шаардлага гарсан тохиолдолд сонгон шалгаруулах комисс тухай бүрд нь мэдээлнэ.

2.3.Сонгон шалгаруулалтад бүртгүүлэх иргэн дараахь материалыг бүрдүүлнэ. Үүнд:

- 1/их, дээд сургууль төгссөн гэрчилгээний хуулбар эх хувийн хамт,
- 2/төрсний гэрчилгээ түүнтэй адилтгах баримт бичгийн хуулбар эх хувийн хамт,
- 3/иргэний үнэмлэхний хуулбар,
- 4/нийгмийн даатгалын дэвтэр болон бусад ажил эрхлэлтийг тодорхойлох баримт бичгийн хуулбар эх хувийн хамт,
- 5/ял шийтгүүлж байгаагүй талаар эрх бүхий байгууллагын тодорхойлолт,
- 6/төрийн албан хаагчийн анкет,
- 7/иргэн зөвлөлийн гишүүнд тавигдах шаардлагыг хангаж буй, шаардлагатай мэдлэг ур чадварыг эзэмшиж буй талаар өөрөө тайлбарлан бичсэн товч танилцуулга,
- 8/холбогдох бусад материал.

Гурав. Сонгон шалгаруулах комисс байгуулах

3.1.Төрийн албан хаагчийн төлөөллийг сонгон шалгаруулах бүрт Төрийн албаны зөвлөлийн шийдвэрээр холбогдох байгууллагуудтай зөвшилцөн Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын алба, Төрийн албаны зөвлөл, Шүүхийн ерөнхий зөвлөл, Үндэсний аудитын газар, Төрийн албаны зөвлөлийн дэргэдэх Олон нийтийн хяналтын зөвлөлийн төлөөлөл бүхий 5 хүний бүрэлдэхүүнтэй комиссыг байгуулна.

3.2.Комиссын бүрэлдэхүүнд орох иргэн сонгон шалгаруулалтыг аливаа хөндлөнгийн нөлөөнд авталгүй шударга явуулах, сонгон шалгаруулах явцаас бусад үед бүртгүүлсэн иргэдтэй харилцахгүй байх талаар амлалт, мэдүүлгэд гарын үсэг зурж Төрийн албаны зөвлөлд хүлээлгэн өгнө.

3.3.Комисс нь дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

1/сонгон шалгаруулалтын материалыг хүлээн авч, хянан нэгтгэх,
2/шаардлагатай тохиолдолд бүртгүүлсэн иргэдийн талаар нэмэлт тодруулга авах,

3/бүртгүүлсэн иргэд шаардлага хангаж буй эсэх талаар холбогдох баримтад тулгуурлан санал дүгнэлт гаргах,

4/бүртгүүлсэн иргэдийн боловсрол, туршлага, ур чадварт үнэлгээ өгөх,

5/Улсын Их Хуралд тодорхой тооны иргэдийг төрийн албан хаагчийн төлөөллөөр нэр дэвшүүлэхээр санал болгох,

6/сонгон шалгаруулалтын материалыг зохих журмын дагуу цэгцэлж архивт шилжүүлэх.

3.4.Комиссын ажиллах нөхцөлийг Төрийн албаны зөвлөлийн Ажлын алба хангаж, дэмжлэг үзүүлж ажиллана.

3.5.Төрийн албаны тухай /шинэчилсэн найруулга/ хууль дагаж мөрдөгдөж эхлэхээс өмнө сонгон шалгаруулалтыг явуулахад төрийн захиргааны чиглэлээр тогтвортой үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагын төлөөллийг энэ журмын 3.1-д заасан Олон нийтийн хяналтын зөвлөлийн оронд комиссын бүрэлдэхүүнд оруулна.

Дөрөв. Урьдчилсан сонгон шалгаруулалт явуулах

4.1.Бүртгүүлсэн иргэд нэр дэвшигчид тавигдах шаардлагыг хангаж буй эсэх талаар комисс холбогдох баримтад тулгуурлан хуралдаанаараа дараахь асуудлаар санал дүгнэлт гаргана.

1/төрийн жинхэнэ албан тушаалд 15-аас доошгүй жил ажилласан байх, үүнээс эрхэлсэн түшмэлийн болон түүнээс дээших албан тушаалд 5-аас доошгүй жил ажилласан байх шаардлагыг хангаж буй эсэх,

2/төрийн удирдлага, эдийн засаг, эрх зүй, боловсролын чиглэлээр мэргэшсэн байх шаардлагыг хангаж буй эсэх,

4.2.Комиссын гишүүн бүртгүүлсэн иргэдийн талаар санал дүгнэлт гаргах болон тэдний боловсрол, туршлагад үнэлгээ өгөхдөө хэрэв ашиг сонирхлын зөрчил үүсэхээр байвал энэ талаар мэдэгдэх үүрэгтэй. Энэ тохиолдолд тухайн иргэний хувьд санал дүгнэлт, үнэлгээ өгөхгүй.

4.3.Эрхэлсэн түшмэлийн болон түүнээс дээших албан тушаал хашсан эсэхийг тодорхойлохдоо төрийн захиргааны албан тушаалын хувьд Засгийн

газрын холбогдох асуудлыг зохицуулсан тушаал, шийдвэрийг; төрийн тусгай албан тушаалын хувьд тусгай албан тушаалыг захиргааны албан тушаалтай дүйцүүлэн үзэх үндэслэлийг тогтоон тодорхойлно.

4.4.Өмнөх заалтад дурдсан аливаа асуудлаар шаардлага хангасан гэсэн санал дүгнэлттэй иргэд сонгон шалгаруулалтын дараагийн шатанд орно.

Тав. Сонгон шалгаруулалт явуулах

5.1.Сонгон шалгаруулалтаар бүртгүүлсэн иргэдийн боловсролд 30 хүртэл оноо, туршлагад 40 хүртэлх оноо, ур чадварт 30 хүртэлх оноогоор үнэлгээ өгч онооны дарааллаар жагсаалт гаргана.

5.2.Комисс үнэлгээ өгөхдөө энэ журмын 1.3-т заасан нэг хүйсийн хүн хэт давамгайлахгүй байх, мэргэшлийн хувьд аль болох олон янзын төлөөллийг хангах, улс төрийн аль нэг хүчинд ажиллаж байсан иргэн гишүүдийн талаас илүүгүй байх зарчмыг харгалзан үзнэ.

5.3.Боловсролын түвшинд доорхи хүснэгтэд үзүүлсэн үнэлгээг өгнө:

Боловсролын зэрэг	Бакалавр	Магистр	Доктор
Оноо	10	10	10

5.4.Боловсролын түвшин бүрт зөвхөн нэг баримт бичигт үнэлгээ өгнө.

5.5.Туршлагад үнэлгээ өгөхдөө комиссын хурлаар хэлэлцэн хамтын шийдвэрээр нэр дэвшигч тус бүрийн ажилласан байдалд дараах хүснэгтэд үзүүлсэн үнэлгээг өгнө:

Ажилласан албан тушаалын ангилал	Дэс түшмэл	Ахлах түшмэл	Эрхэлсэн түшмэл	Тэргүүн түшмэл
Оноо	5	8	12	15

5.6.Туршлагад комисс үнэлгээ өгөхдөө төрийн удирдлага, эдийн засаг, эрх зүй, боловсролын салбарт тухайн түшмэлийн ангилалд хамгийн олон жил ажилласан иргэнд хамгийн өндөр оноог өгч бусад иргэний ажилласан жил, мэргэшсэн байдлыг хамгийн өндөр оноо авсан иргэний тухайн түшмэлийн ангилалд ажилласан жил, мэргэшсэн байдалтай харьцуулан үзэж үнэлгээ өгнө.

5.7.Комисс ур чадварт үнэлгээ өгөхөөс өмнө боловсрол, туршлагын үнэлгээгээр хамгийн өндөр оноо авсан 5 иргэний талаар тодорхой мэдээлэл өгч чадах холбогдох байгууллага, албан тушаалтан, иргэнээс ажил байдлын тодорхойлолт болон ур чадварын талаар утсаар эсхүл бичгээр лавлаж тодруулга авсан байна.

5.8. Ур чадварт үнэлгээ өгөхдөө комиссын хурлаар хэлэлцэн хамтын шийдвэрээр нэр дэвшигч тус бүрийн дараах чиглэлтэй холбоотой ур чадварт иргэний хамрагдсан сургалт, судалгаа шинжилгээний ажил, ажлын туршлагыг нотлох холбогдох баримт, өмнөх хэсэгт заасан ажил байдлын тодорхойлолт, тодруулгад үндэслэн тус бүр 10 хүртэл оноогоор дүгнэнэ. Үүнд:

1/Хууль тогтоомжийн хэрэгжилтийн явц үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, үр дүнг дээшлүүлэх, илэрсэн зөрчлийг арилгах, хүний нөөцийн аудит хийх, төрийн албан хаагчтай холбоотой маргаан шийдвэрлэх ур чадвар,

2/Төрийн албаны шинэтгэлийн болон сайн засаглалын зарчмыг хэрэгжүүлэх бодлогын хэрэгжилтийг хангах, стратеги төлөвлөгөө боловсруулах, үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх ур чадвар,

3/Төрийн албаны ангилал зэрэглэл, цалин хөлс, зэрэг дэв, тусгай шаардлага, шатлан дэвшүүлэх тогтолцоог боловсронгуй болгох болон төрийн албаны чадавхийг бэхжүүлэх хөтөлбөрийн агуулгыг тогтоох, уялдан зохицуулах ур чадвар.

5.9. Комисс нийт оноогоор хамгийн өндөр оноо авсан 5 иргэний ажиллаж буй эсхүл өмнө нь ажиллаж байсан төрийн байгууллагуудаас тухайн иргэн сахилгын шийтгэлээр төрийн албанаас халагдаж эсхүл ёс зүйн зөрчил гаргаж байсан эсэх талаар лавлагаа авч Зөвлөлийн гишүүнд тавигдах шаардлагыг хангаж буй эсэхийг нягтална.

5.10. Сонгон шалгаруулалтын дүнг нэгтгэх үед тодорхой субъектээс нэр дэвшигчтэй нэг нутгийн, нэг анги хамт төгссөн, хамаарал бүхий иргэний нэрийг жагсаалтаас хасна.

5.11. Хэрэв сонгон шалгаруулалтад оролцогчид өөр хоорондоо нэг нутгийн, нэг анги хамт төгссөн, хамаарал бүхий этгээд байвал тэдгээрээс аль бага оноотойг жагсаалтаас хасна.

Зургаа. Төрийн албан хаагчийн төлөөлөлд санал болгох, Улсын Их Хуралд нэр дэвшүүлэх

6.1. Комисс үнэлгээг эцэслэн нягталж хамгийн өндөр үнэлгээ авсан 5 иргэний нэр, онооны жагсаалт, холбогдох материал, сонгон шалгаруулалт явуулсан тухай тайланг Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороонд хүргүүлнэ.

6.2. Төрийн байгуулалтын байнгын хороо комиссоос санал болгосон иргэдийг Улсын Их Хуралд суудал бүхий намын төлөөлөлтэй уулзуулах уулзалтыг зохион байгуулж санал болгосон иргэдтэй төрийн албаны шинэчлэл, төрийн албаны хүний нөөцийн бодлого, холбогдох бусад асуудлаар харилцан ярилцах боломжийг бүрдүүлнэ.

6.3.Төрийн байгуулалтын байнгын хороо комиссоос санал болгосон иргэдийг Улсын Их Хуралд суудал бүхий намын төлөөлөлтэй онооны дарааллаар хүн тус бүрээр зөвшилцөн төрийн албан хаагчийн төлөөллөөр нэр дэвшүүлэх хоёр иргэнийг тодруулан Улсын Их Хуралд нэр дэвшүүлнэ.

6.4.Хэрэв зөвшилцөлд хүрээгүй тохиолдолд санал болгосон иргэдээс онооны дарааллыг баримтлан нэр дэвшүүлнэ.

6.5.Төрийн байгуулалтын байнгын хороо уулзалт ярилцлагын дэлгэрэнгүй тэмдэглэлийг Улсын Их Хурлын Тамгын газрын цахим хуудасны зохих хэсэгт ажлын 5 хоногт багтаан байршуулна.

Долоо. Бусад зүйл

7.1.Төрийн албан хаагчийн төлөөллийг сонгон шалгаруулахтай холбоотой гомдлыг маргаан үүсгэж шалгах шаардлагатай бол холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

7.2.Төрийн албан хаагчийн төлөөллийг сонгон шалгаруулахад худал тодорхойлолт гаргаж өгсөн, бусад аливаа хэлбэрээр сонгон шалгаруулалтыг шударгаар явуулахтай нийцэхгүй үйлдэл гаргасан этгээдэд сахилгын шийтгэл хүлээлгэх үндэслэл болох бөгөөд тэр талаар сонгон шалгаруулалт явуулсан талаарх тайланд тодорхой тусгана.

7.3.Сонгон шалгаруулалтад оролцогч Зөвлөлийн гишүүнд тавигдах шаардлагын талаар аливаа худал баримт бүрдүүлсэн болох нь илэрсэн бол түүний сонгон шалгаруулалт хүчингүйд тооцогдоно.

---oOo---